



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
Дараах хаягаар харилцана уу.**

**Тэргүүлэх аудитор
Өрөөний утас: 70483413**

**Аудитын менежер
өрөөний утас: 70484055**

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Төлбөр зөрчлийн жагсаалт
- Хавсралт 4: Албан шаардлага
- Хавсралт 5: Аудит хийсэн санхүүгийн
тайлан
- Хавсралт 6: Төсвийн гүйцэтгэлийн
тайлан

**ТАБ-ын хаяг:
Говь-Алтай аймаг дахь
Төрийн аудитын газар
Байршил: Алтай хот
Цахим хуудас: www.audit.mn**

Тайланг бэлтгэсэн:	АГУУЛГА	3
Говь-Алтай аймгийн Аудитын газрын I баг	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт Нэг: Ерөнхий зүйл	4
Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр Утас: 99489309	1.1. Аудитын зорилт, хамарсан хүрээ 1.2. Аудитын арга зүй 1.3. ОНТЕЗ- ийн 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал	5
Аудитын менежер Д.Эрдэнэчимэг Утас: 99175677	Хоёр: Санхүүгийн дотоод хяналт	6
Ахлах аудитор Ж.Бүжинханд Утас:94008898	Гурав: Шилэн дансны мэдээлэл	6
Шинжээч: Г.Энхдэлгэр Утас:99002291	Дөрөв: Материаллаг байдлыг тодорхойлох	6
Ахлах аудитор: Г.Цэцэгмаа Утас: 99489399	Тав: Санхүүгийн тайлангийн дансдын талаар	6
2017 оны 04 дүгээр сар	5.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зййл байвал 70483413, 70484055 дугаарын утас, 70484030 дугаарын факсаар харилцана уу.	5.1.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар	
	5.1.2 Арилжааны банк дахь харлцах дансдын талаар	7
	5.2. Авлагын бүртгэл, тайлагнал	
	5.2.1 Авлагын бүтэцийн талаар	
	5.2.2 Авлагын үлдэгдэл, тооцоо нийлэлт	9
	5.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал	
	5.3.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар	
	5.3.2 Үнэ төлбөргүй авсан болон акталсан бараа материал	
	5.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	11
	5.4.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар	
	5.4.2 Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	
	5.4.3 Үнэ төлбөргүй авсан болон акталсан үндсэн хөрөнгө	
	5.4.4 Улсын төсвөөс орон нутгийн өмчид шилжүүлсэн хөрөнгө	
	5.5 Өр төлбөрийн бүртгэл тайлагнал	13
	5.5.1 Өр төлбөрийн бүтцийн талаар	
	5.5.2 Өр төлбөрийн дансны үлдэгдэл тооцоо нийлэлт	
	5.6 Орлого, татаас, санхүүжилт	14
	5.6.1 Улсын төсвийн орлого	
	5.6.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт	
	5.6.3 Өөрийн орлого	
	5.6.4 Татварын орлого	
	5.7 Зарлагын талаар	17
	5.7.1 Санхүүжилтийн зарцуулалт.	
	5.7.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт	
	5.7.3 Тусгай шилжүүлгийн зарцуулалт	
	5.7.4 ОНӨААТҮГ-ын төлөвлөгөө, гүйцэтгэл	
	5.8 Хуримтлагдсан үр дүнгийн талаар	21
	5.9 Эзэмшигчийн өмчийн талаар	
	5.10 Хөрөнгө оруулалтын талаар	22
	Зургаа: Санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	25
	Долоо: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	26
	Найм: Аудитын санал зөвлөмжийн үндэслэл	
Хаяг: Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг	Холбогдох байгууллагын санал Саналын хариу тайлбар Хавсралтууд	27

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БГ	Боловсролын газар
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
БХНС	Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгө
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол Улс
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуй тооцоот үйлдвэрийн газар
ОТБТБАҮЭХХОАТ	Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхэлсэн хувь хүний орлогын албан татвар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТББАТ	Түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөр
УИХ	Улсын их хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХО	Хөрөнгө оруулалт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Аудит хийсэн хууль эрх зүйн үндэслэл

Үндэсний аудитын газрын харьяа Говь-Алтай аймаг дахь төрийн Аудитын газар Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн дагуу орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

1.2 Аудитын зорилт

Аудитыг Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу явуулав.

Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт бөгөөд Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Аудитад аймгийн орон нутгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангууд болон тэдгээрийн гүйцэтгэлийг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамруулсан болно. Говь-Алтай аймаг дахь Төрийн Аудитын газар Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу бүх шатны төсвийн захирагчдын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

1.3 Аудитын арга зүй, хамарсан хүрээ

Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого зарчмуудыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болгон, СТАУС программ хангамжийг ашиглан хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, эрсдэлтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалган ажилласны зэрэгцээ Төрийн сангийн хуулга, бүртгэл хөтлөлтийг дансны гүйлгээтэй тулган шалгаж, баталгаажуулах аргыг ашиглан аудитыг хийлээ.

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлан нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ноос өмнө хийхээр төлөвлөсөн бөгөөд аудитыг 04 сарын 01-нээс 04 сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ. Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг баримтлан, НББ-ийн тухай хуулийн 5.1, 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузал суурийг хэрэглэж, Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан ба тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлсэн байна.

ОНТЕЗ-ийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргасан болно.

Төсвийн тухай хуулийн 54.2-д **"Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна"** гэж заасны дагуу Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 150 төсөвт байгууллага, 58 төсөл сан, 21 төрийн сан, болон 7 ОНӨААТҮГ бүгд 236 санхүүгийн тайланг хамруулсан.

Дээрх байгууллагуудаас "Орон сууцны алба" ОНӨААТҮГ, "Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ, "Зураг зүйн товчоо" ОНӨААТҮГ зэрэг нийт 3 байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэхь заалтанд заасан хугацаанд тайлангаа ирүүлээгүйн улмаас санхүүгийн тайланд аудит хийгдээгүй.

Аудитын газрын хүний нөөц болон цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан, мөн УАГ-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн", "ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтын үр дүн"-д нийцлийн болон гүйцэтгэлийн аудитыг хийж байгаатай холбогдуулан аймгийн төвийн болон сумдын ОНХС-гийн орлого, зардлын зарцуулалт, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тайланг аудитад хамруулж үзээгүй болно.

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангаар:

- ❖ Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын хоорондын ажил гүйлгээний давхардсан дүнг үр дүнгийн тайланд 25,148.1 сая төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд 60,773.6 сая төгрөгөөр устган тохируулсан.
- ❖ Сум хөгжлийн сангийн авлагыг зээлийн болон зээлийн хүүгийн авлагаар нь ангилж бүртгүүлсэн. Тус сангийн зээлийн хүүгийн орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогоор, зээлийн төлөлтийг төсөв болон дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтөөр тайлагнасан болно.

Дээрх тайлангуудыг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан "Нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу "Э-тайлан" программаар бэлтгэн гаргажээ.

ХОЁР.САНХҮҮГИЙН ДОТООД ХЯНАЛТ

Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагч 2016 онд санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол улсын нягтлан бодох бүртгэл, Төсвийн тухай хууль болон Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого заавар, журмыг баримтлан ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.10-д заасан ТЕЗ нар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, 69-р зүйлийн 69.1-д заасан ТЕЗ бүр дотоод аудитын алба байгуулж ажиллах тухай хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Аудитаар Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед "бага" гэж тооцсон ба дахин хянахад нэгтгэсэн тайлангаар төсвийг хэтрүүлэн зарцуулсан, материаллаг хэмжээний зөрчил илэрч байгаа нь цаашид дотоод хяналтыг сайжруулж, үр дүнтэй, үр нөлөөтэй хяналт хийн, хэрэгжилтийг хангуулж ажиллах шаардлагатай байна.

ГУРАВ:ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу явуулахаас гадна салбарын хэмжээнд хяналт тавьж ажиллахаар заасан. Орон нутгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд хуулинд заасан дээрх мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсанд байршуулж байгааг санхүүгийн тайлангийн аудитаар давтан үзэхэд аймгийн Мал хамгаалах сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 57.4 сая төгрөгийн мэдээллийг оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна. Улмаар Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д / Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна/ гэсэн хариуцлага ногдуулахаар байгаа тул эдгээр сангуудын мэдээллийг шилэн дансанд байршуулж хэвшвэл зохистой.

ДӨРӨВ: МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг суурь болгон авч түүний 2.0 хувиар тооцон **1,153.3** сая төгрөгөөр тогтоов.

ТАВ: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДАНСДЫН ТАЛААР

5.1 МӨНГӨН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

5.1.1 МӨНГӨН ХӨРӨНГИЙН БҮТЦИЙН ТАЛААР

ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- ✓ Төрийн сангийн дансны үлдэгдэл
- ✓ Төсөл сангийн харилцах дансдын үлдэгдэл
- ✓ ОНӨҮГ-уудын арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл
- ✓ ОНӨҮГ-ын кассад байгаа бэлэн мөнгө

ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2015 оны эцэст 2,912.6 сая төгрөг байснаас 24.6 хувиар өсөж 3,629.3 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 98.7 хувь буюу 3,581.1 сая төгрөг төрийн санд, 1.2 хувь буюу 45.5 сая төгрөг арилжааны банкинд, 0.1 хувь буюу 2.8 сая төгрөг кассат байна.Хавсралт-1


ОНТЕЗ-ийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2016 оны үлдэгдлийн бүтэц
байгууллагын төрлөөр харуулбал: /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассат байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Төрийн сан	Арилжааны банк
Кассад байгаа бэлэн мөнгө:	13.92	2.84	2.84	-	-
Төгрөг	13.92	2.84	2.84		
Банкинд байгаа бэлэн мөнгө:	2,898.66	3,626.42	-	3,581.05	45.37
Байгууллагын төрөгийн харилцах /халамжийн сан, ОНӨҮГ, бусад/	61.39	45.35			45.35
Гадаад валют	0.01	0.02			0.02
Төрийн сангийн харилцах	2,837.26	3,581.05		3,581.05	
Бусад төсөл нөөцийн харилцах					
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	2,912.58	3,629.26	2.84	3,581.05	45.37
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:					
Төсвийн байгууллага	365.13	1,398.88	0.06	1,395.04	3.81
Төрийн сан	1,767.20	1,146.02		1,145.57	0.45
Төсөл сан	739.58	1,040.45		1,040.44	
ОНӨҮГ	40.67	43.91	2.78		41.11
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	2,912.58	3,629.26	2.84	3,581.05	45.37

Мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдлийн 38.5 хувь нь орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл, 31.6 хувь нь төрийн сангийн үлдэгдэл, 28.7 хувь нь төсөл сангийн, 1.2 хувь нь ОНӨҮГ-ын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болох 1,395.0 сая төгрөг нь ОНХСангийн зарцуулагдаагүй үлдэгдэл, байна. Оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,033.7 сая төгрөгөөр, төсөл сангийн үлдэгдэл 300.9 сая төгрөгөөр, ОНӨҮГ-ын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3.2 сая төгрөгөөр тус тус өссөн харин төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 621.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бүтцээр нь харуулбал: 62.0 хувийг СХС-ийн үлдэгдэл, 14.0 хувийг БХНСС-гийн барьцаа хөрөнгө, 7.0 хувийг МХС-ийн үлдэгдэл, 2.0 хувийг ТЭДС-гийн үлдэгдэл, 14.0 хувийг нэмэлт санхүүжилтын татан төвлөрүүлэлтийн үлдэгдэл тус тус эзэлж байна.



5.1.2 АРИЛЖААНЫ БАНК ДАХЬ ХАРИЛЦАХ ДАНСДЫН ТАЛААР:

Арилжааны банкинд байршиж буй мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 91 хувь буюу 41.2 сая төгрөг нь ОНӨҮГ-ын үлдэгдэл, 8 хувь буюу 3.8 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын үлдэгдэл, 0.5 сая төгрөг нь ОНӨО-ын төрийн санд төвлөрүүлээгүй арилжааны банкны үлдэгдэл байна.

Орон нутгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг нэгж байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, баталгаажуулалт, санхүүгийн сахилга, хариуцлагатай холбоотой дор дурдсан нийтлэг зөрчил илэрсэн байна. Үүнд:

- ❖ Дэлгэр сумын цэцэрлэгийн санхүүгийн тайланд кассын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 0.05 сая төгрөгийг тайлагнасан боловч бодитоор мөнгөн хөрөнгө байхгүй, жил дараалан бүртгэсээр ирсэн.

5.2 АВЛАГЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

5.2.1 АВЛАГЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААР:

Орон нутгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл **5,061.1** сая төгрөг байснаас тайлант онд **341.7** сая төгрөгөөр өсч, оны эцэст **5,402.8** сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Авлагын бүтцийг авч үзвэл төсөвт байгууллагатай холбоотой авлага **361.4** сая төгрөгөөр, төсөл сангийн авлага **130.4** сая төгрөгөөр өсөж, төрийн сангийн авлага **11.5** сая төгрөгөөр, ОНӨҮГ-ын авлага **138.6** сая төгрөгөөр тус тус буурчээ. Хавсралт-2

Нийт авлагын үлдэгдлийг бүтэц, байгууллагаар нь харуулбал:


Авлагын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү /сая төгрөгөөр/
Ажиллагчидтай холбогдсон авлага	32.1	64.3	32.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	8.1	11.4	3.3
Татаас, санхүүжилтын авлага	3.6	-	(3.6)
Зээлийн хүүгийн авлага	137.9	197.4	59.5
Дансны авлага /ТӨҮГ/	336.4	168.1	(168.3)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.0	10.0	10.0
Байгууллагаас авах авлага	626.0	237.4	(388.6)
Хувь хүмүүсээс авах авлага	3,805.0	827.3	(2,977.7)
Хувь хүмүүст олгосон зээл	112.0	3,521.0	3,409.0
Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл		365.9	365.9
Нийт авлагын дүн	5,061.1	5,402.8	341.7
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:			
Төсвийн байгууллага	652.5	1,013.9	361.4
Төрийн сан	31.5	20.0	(11.5)
Төсөл сан	3,991.2	4,121.6	130.4
ОНӨҮГ	385.9	247.3	(138.6)
Нийт авлагын дүн	5,061.1	5,402.8	341.7

Нийт авлагын 18.8 хувь нь төсөвт байгууллагын, 0.4 хувь нь төрийн сангийн, 76.3 хувь нь төсөл сангийн, 4.5 хувь нь ОНӨҮГ-ын авлага байна. Төсөл сангийн нийт авлагын 90.2 хувь нь сумдын сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байгаа бол төсөвт байгууллагуудын авлагын 79.5 хувь нь орон нутгийн хөгжлийн сангийн авлага эзэлж байна.

5.2.2 АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, ТООЦОО НИЙЛЭЛТ

Төсөвт байгууллагын авлагыг тодруулбал:

Төсөвт байгууллагын авлага 1,013.9 сая төгрөгөөр тайлагнагдсаны 11.4 хувь буюу 116.1 сая төгрөг нь орон нутгийн байгууллагын, 7.1 хувь буюу 72.0 сая төгрөг нь боловсрол, соёлын салбарын, 1.4 хувь буюу 13.9 сая төгрөг нь эрүүл мэндийн салбарын, 79.5 хувь буюу 806.4 сая төгрөг нь ОНХС-гийн, 0.5 хувь буюу 5.5 сая төгрөг нь аймаг хөгжлийн сангийн авлага байна.



Төсөл сангийн авлагыг тодруулбал:

Төсөл сангийн авлагын 90.2 хувь буюу 3,716.7 сая төгрөг нь СХС-гийн, 6.8 хувь буюу 280.9 сая төгрөг нь мал хамгаалах сангийн, 3.0 хувь буюу 122.1 сая төгрөг нь ТЭДС-гийн, 0.01 хувь буюу 1.9 сая төгрөг нь Алтай сумын БХНСС-гийн авлага байна.

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн судалгааг хийж зээлдэгчдээс авах авлагын үлдэгдлийг тооцоход хувь хүмүүст олгосон зээлийн авлага 3,521.0 сая төгрөг, зээлийн хүүгийн авлага 195.7 сая төгрөг, нийт 3,716.7 сая төгрөгийн авлагатай байна.

2014 онд УАГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “СХС-гийн хөрөнгийн зарцуулалтын үр дүн”-д хийсэн нийцлийн аудит болон 2014, 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,375.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон боловч 508.7 сая төгрөгийн зөрчлийг барагдуулан, 866.4 сая төгрөгийг барагдуулаагүй байна. Мөн 2016 оны санхүү тайлангийн аудитаар 2015 оны СТА-аас хойших хугацаанд гэрээний дагуу үндсэн зээл, хүүгээ төлөөгүйд нэмж 961.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон бөгөөд, нийт 1,828.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн үндсэн зээл, зээлийн хүү, алдангийг төлөөгүй байна.

Иймд СХС-гийн их хэмжээний авлагыг барагдуулах арга хэмжээ авч, алдангийг хөшүүрэг болохуйц түвшинд тогтоож, бүх талын хариуцлагыг сайжруулан ажиллах нэн шаардлага бий болжээ. Хавсралт-3

Төрийн сангийн авлагыг тодруулбал:

Төрийн сангийн авлага нийт 20.0 сая төгрөг байгаа нь 2012 онд үүссэн 4 жилийн насжилттай “Нийтлэг үйлчилгээ” ОНӨТҮГ-аас авах тоног төхөөрөмжийн авлага байна.

ОНӨТҮГ-ын авлагыг тодруулбал :

ОНӨТҮГ-ын авлага өмнөх оноос 138.6 сая төгрөгөөр буурч 247.3 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд Дарив сумын “Дулаан” ОНӨААТҮГ, “Гэгээн нуур” цэвэр ус ОНӨААТҮГ, Барилгын зураг төсвийн товчоо, “Ундарга Алтай” ОНӨААТҮГ, “Нийтлэг үйлчилгээ” ОНӨТҮГ-уудтай холбоотой авлага байна.

Орон нутгийн ТЭЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг нэгж байгууллагуудын авлага өглөгийн дэлгэрэнгүй судалгаа хийхэд дараах байдалтай байна. Үүнд:

- ❖ Орон нутгийн төсвийн болон ОНӨААТҮГ-ын 196.8 сая төгрөгийн авлагыг, 314.9 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Хавсралт-4
- ❖ Нэгж байгууллагуудын санхүүгийн тайланд тусгагдсан нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өглөгийг Нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн судалгаатай тулган үзэхэд 16.4 сая төгрөгөөр, татварын авлага өглөгийг Татварын хэлтсээс ирүүлсэн судалгаатай тулган үзэхэд 32.3 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнажээ. Энэ нь санхүүгийн тайлангийн аудитаар “Итгэл” үзүүлсэн болон түүвэрт хамрагдсан төсөвт байгууллагуудтай ихэвчлэн холбоотой байна. Хавсралт-5
- ❖ Орон нутгийн ТЭЗ-ийн багцад хамаарах нэгж байгууллагуудын удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр 118.3 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгож, НДШ-д 4.3 сая төгрөг, ХХОАТ-т 0.7 сая төгрөг, тэмдэгтийн хураамжид 0.3 сая төгрөг төсвөөс төлж 123.5 сая төгрөгийг буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироожээ. Хавсралт-6

5.3 БАРАА МАТЕРИАЛЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

5.3.1. БАРАА МАТЕРИАЛЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААР :

Орон нутгийн ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл **4,330.4** сая төгрөг /нөөцийн барааг оруулан/ байснаас тайландт онд **1,250.2** сая төгрөгөөр өсч, оны эцэст **5,580.6** сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 5,625.3 сая төгрөгийн бараа материал худалдан авсан бөгөөд хандив тусламжаар 152.7 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээр 1,251.9 сая төгрөгийн, бүтцийн өөрчлөлтөөр 3.7 сая төгрөгийн, шилжүүлэн авсан 133.8 сая төгрөгийн, нийт 7,167.3 сая төгрөгөөр бараа материалаар нэмэгдэж тайлант онд 5,629.4 сая төгрөгийн

бараа материалыг зарцуулж, 287.8 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж 5,580.5 сая төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна. Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг нэгж байгууллагуудын бараа материалыг нэр төрлөөр нь дэлгэрэнгүйгээр нэгтгэлээ. Хавсралт-7, 8

Бараа материалын үлдэгдлийг бүтэц, байгууллагаар нь харуулбал:
/сая төгрөгөөр/

Бараа материалын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү /өссөн+, буурсан-/
Тусгай зориулалтын материал	748.80	813.20	64.4
Эм боох материал	95.20	78.30	(16.9)
Дуусаагүй үйлдвэрлэл	7.40	7.40	-
Бэлэн бүтээгдэхүүн	91.00	148.60	57.6
Бичиг хэргийн материал	53.70	55.70	2.0
Аж ахуйн материал	1,407.60	1,487.00	79.4
Сэлбэг хэрэгсэл	38.20	36.20	(2.0)
Түлш, шатах тослох материал	325.30	311.60	(13.7)
Барилгын засварын материал	52.70	44.10	(8.6)
Хүнсний материал	293.90	303.70	9.8
Бусад хангамжийн материал	829.30	715.90	(113.4)
Мал амьтад	229.50	1,495.40	1,265.9
Нөөцийн бараа	157.80	83.50	(74.3)
Нийт бараа материалын дүн	4,330.4	5,580.6	1,250.2
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:			
Төсвийн байгууллага	3,472.9	4,860.9	1,388.0
Төрийн сан	-	-	-
Төсөл сан	97.3	114.5	17.2
ОНӨҮГ	760.2	605.2	(155.0)
Нийт бараа материалын дүн	4,330.4	5,580.6	1,250.2

Нийт бараа материалын үлдэгдлийн 87.1 хувийг төсөвт байгууллагын, 2.1 хувийг төсөл сангийн, 10.8 хувийг ОНӨҮГ-ын бараа материал тус тус эзэлжээ.

Хангамжийн материалын дансдын үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зориулалтын материал 64.4 сая төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүн 57.6 сая төгрөгөөр, бичиг хэргийн материал 2.0 сая төгрөгөөр, аж ахуйн материал 79.4 сая төгрөгөөр, хүнсний материал 9.8 сая төгрөгөөр, мал амьтад 1,265.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг нэгж байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материалын хадгалалт хамгаалалт, бүртгэлтэй холбоотой дор дурдсан нийтлэг зөрчил илэрсэн байна. Үүнд:

- ❖ Бараа материал, мөнгөн хөрөнгийг эд хариуцагчийн тайлан, кассын тайланд тайлагнаагүй нягтлан бодох бүртгэлд шууд зардлаар тайлагнасан 41.0 сая төгрөгийн зөрчил ГХБХБГ, Биеийн тамирын спортын газар, Алтай, Бигэр, Бугат, Шарга, Халиун, Тонхил сумуудын төсөвт байгууллагуудад илэрсэн.
- ❖ Няравын тайланд бараа материалын орлогыг дутуу авсан 13.8 сая төгрөгийн зөрчил Халиун, Хөхморьт, Чандмань сумын төсөвт байгууллагуудад илэрсэн.
- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар малжуулсан малыг данс бүртгэлд тусгаагүй 47.9 сая төгрөгийн зөрчил Бугат, Жаргалан, Шарга сумдын ЗДТГ-т илэрсэн.
- ❖ Хүнсний материалын тендерт шалгараагүй иргэн, ААНБ-аас хүнсний материалын худалдан авалт хийсэн 6.8 сая төгрөгийн зөрчил Есөнбулаг сумын цэцэрлэгүүдэд илэрсэн.
- ❖ Байгууллагын удирдлага болон няравтай нэгдмэл сонирхол бүхий этгээд төсвийн байгууллагад хүнсний материал нийлүүлсэн 22.5 сая төгрөгийн зөрчил Есөнбулаг сумын Оюуны Өргөө цэцэрлэг, Оюуны түлхүүр бага сургууль, Дэлгэр сумын Гуулин тосгоны сургуульд илэрсэн.
- ❖ Хүнсний материал, эмийг үндэслэлгүйгээр акталсан 1.9 сая төгрөгийн зөрчил Дарив, Жаргалан, Цээл, Эрдэнэ сумуудын төсөвт байгууллагуудад илэрсэн.

- ❖ Дэлгэр сумын Цэцэрлэг нь хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн 10.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
- ❖ Байгууллагын удирдлагын шийдвэргүйгээр бараа материалыг тооллогын комисс устган бараа материалаас хассан 1.7 сая төгрөгийн зөрчил Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэгт илэрсэн.

5.4 ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

5.4.1 ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААР

Нэгтгэсэн тайлангийн хувьд оны эхэнд 155,944.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 435.9 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, хандив тусламж, бусад эх үүсвэрээр 8,067.1 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, 1,667.7 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 667.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 1,323.1 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн оны эцэст 164,125.1 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Оны эцэст 72,663.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй байгаа бөгөөд 91,461.8 сая төгрөгийн цэвэр үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Хавсралт-9, 10

Үндсэн хөрөнгийн бүтэц, байгууллагаар нь харуулбал:

/сая төгрөгөөр/			
Бараа материалын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү /өссөн+, буурсан-/
Барилга байгууламж, орон сууц	112,159.3	116,658.8	4,499.5
Тээврийн хэсэгсэл	5,456.0	5,820.8	364.8
Машин тоног төхөөрөмж	11,140.6	12,284.7	1,144.1
Тавилга эд хогшил	4,980.9	5,372.2	391.3
Зам гүүрийн байгууламж	13,999.0	15,570.0	1,571.0
Батлан хамгаалахын тоног төхөөрөмж	5.2	5.2	-
Түүх соёлын дурсгалт зүйл	1,028.2	1,025.3	(3.0)
Бусад үндсэн хөрөнгө	3,859.4	4,300.4	441.0
Нюмын фонд	507.6	568.1	60.5
Дуусаагүй барилга байгууламж	2,580.0	2,235.0	(345.0)
Програм хангамж	156.4	191.4	34.9
Бусад биет бус хөрөнгө	72.2	93.4	21.2
Нийт бараа материалын дүн	155,944.8	164,125.1	8,180.3
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:			
Төсвийн байгууллага	144,527.9	152,607.5	8,079.6
Төрийн сан			-
Төсөл сан			-
ОНӨҮГ	11,417.0	11,517.6	100.6
Нийт бараа материалын дүн	155,944.8	164,125.1	8,180.3

2015 оны жилийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 164,125.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэгтгэгдсэн байгаагийн 7.0 хувь нь ОНӨҮГ-ын, 93.0 хувь нь төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгө байна.

Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдлийн 99.8 хувийг биет хөрөнгө, 0.2 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг нэгж байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материалын хадгалалт хамгаалалт, бүртгэлтэй холбоотой дор дурдсан нийтлэг зөрчил илэрсэн байна. Үүнд:

- ❖ Хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийхэд материал дутагдсан 1.1 сая төгрөгийн зөрчил Дэлгэр сум, Шарга, Есөнбулаг сумдын төсөвт байгууллагуудад илэрсэн.
- ❖ Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх комисс томилоогүй, тооллого хийгээгүй, хангалтгүй хийсэн, тооллогын бүртгэлийн дүн НББ-ийн үлдэгдлээс зөрүүтэй нийт 7,918.1 сая төгрөгийн зөрчил Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Төгрөг, Хөхморьт, Цогт сум, Баянтоорой тосгоны төсөвт байгууллагуудад илэрсэнд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.
- ❖ Орон нутгийн өмчийн албаны мэдээлэлтэй тулгахад төсөвт байгууллагын хөрөнгийг орон нутгийн өмчийн албанд нэгтгүүлээгүй 1,747.1 сая төгрөгийн зөрчил Алтай сум, Тонхил, Хөхморьт, Халиун, Цогт сум, Баянтоорой тосгоны төсөвт байгууллагуудад илэрсэн.
- ❖ Дуусаагүй барилга байгууламжид бүртгэгдсэн хөрөнгийг дуусгавар болгон ашиглалтад оруулаагүй 635.0 сая төгрөгийн зөрчил Цээл сумын ЭМТ, Есөнбулаг сумын 3 дугаар цэцэрлэгт илэрсэн.
- ❖ Тус байгууллагын эзэмшиж буй төрийн өмчийн дүн нь байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дүнгээс зөрүүтэй 1,902.5 сая төгрөгийн зөрчил, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд анхны үнээ элэгдлээрээ бүрэн нөхөж үнэгүйдсэн, НББ-ээр хяналт тавих боломжгүй 295.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, хөрөнгийн элэгдэл зөрүүтэй 1.0 сая төгрөгийн зөрчил нь сумдын ЭМТ-үүдэд илэрсэн.

5.5 ӨР ТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

5.5.1 ӨР ТӨЛБӨРИЙН БҮТЦИЙН ТАЛААР

Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл **5,709.4** сая төгрөг байснаас тайлангийн эцэст **5,622.3** сая төгрөгт хүрч, **87.1** сая төгрөгөөр буурсан байна.Хавсралт-11

Нийт өр төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:


Өглөгийн ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Зөрүү /өссөн+, буурсан-/
Ажилчидтай холбоотой өглөг	51.9	41.6	(10.3)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	35.0	37.9	2.9
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	5.0	-	(5.0)
Байгууллагад төлөх өглөг	616.5	562.0	(54.5)
Хувь хүмүүст төлөх өглөг	50.3	6.8	(43.5)
Татварын өр	10.0	7.4	(2.6)
НДШ-ийн өр	1.9	3.8	1.9
Дансны өглөг	110.8	126.5	15.7
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн	31.5	56.8	25.3
Урт хугацаат өр төлбөр	4,796.5	4,779.5	(17.0)
Нийт дүн	5,709.4	5,622.3	(87.1)
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:			
Төсвийн байгууллага	264.8	70.0	(194.8)
Төрийн сан	0.9	1.7	0.8
Төсөл сан	389.5	444.2	54.7
ОНӨҮГазар	5,054.3	5,106.4	52.1
Нийт дүн	5,709.4	5,622.3	(87.1)

Нийт өр төлбөрийн 15.0 хувь нь богино хугацаат өр төлбөр, 85.0 хувь нь “Ундарга Алтай” ОНӨААТҮГ-ын урт хугацаат өр төлбөр байна. Нийт өр төлбөрийг байгууллагаар авч

үзвэл 1.2 хувийг төсөвт байгууллагын, 0.03 хувийг төрийн сангийн, 7.9 хувийг төсөл сангийн, 90.8 хувийг ОНӨҮГ-ын өр төлбөр эзэлжээ.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 70.1 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

БХӨТ-ийн 4.9 хувь нь ажилчидтай холбоотой өглөг, 4.5 хувь нь бараа үйлчилгээний зардлын өглөг, 66.7 хувь нь байгууллагад төлөх өглөг, 0.8 хувь нь хувь хүмүүст төлөх өглөг, 0.9 хувь нь татварын өглөг, 0.5 хувь нь НДШ-ийн өглөг, 15.0 хувь нь дансны өглөг, 6.7 хувь нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл тус тус эзэлж байна.



5.5.2 ӨР ТӨЛБӨРИЙН ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ БАТАЛГААЖУУЛАЛТ, ТООЦОО НИЙЛЭЛТ

Төсөвт байгууллагын өр төлбөрийг тодруулбал:

Төсөвт байгууллагын БХӨТ нь оны эхэнд 264.8 сая төгрөг байснаас тайлант онд 194.8 сая төгрөгөөр буурч 70.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсаны 22 хувь буюу 15.6 сая төгрөг нь орон нутгийн байгууллагын, 24 хувь буюу 17.0 сая төгрөг нь эрүүл мэндийн салбарын, 40 хувь буюу 27.7 сая төгрөг нь боловсрол, соёлын салбарын, 14 хувь буюу 9.6 сая төгрөг нь аймгийн төвийн байгууллагын өглөг байна.

Төсөл сангийн өр төлбөрийг тодруулбал:

Төсөл сангийн өр төлбөрийн 444.2 сая төгрөг байгаагийн:

- ❖ 265.2 сая төгрөг нь аймгийн Мал хамгаалах сангийн ЗГ-ын 197 тогтоолоор 2010-2011 онуудад малжуулсан төслийн хөрөнгийг Хүнс хөдөө аж ахуйн яамд өгөхөөр үүсгэсэн өглөгтэй холбоотой.
- ❖ 92.2 сая төгрөгийн өглөг нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз эзэмшигч ААНБ-уудын нөхөн сэргээлт хийхээр баталгаа буюу барьцаа болгосон хөрөнгөтэй холбоотой.
- ❖ 86.0 сая төгрөгийн өглөг нь ТЭДС-гийн өглөг байна.
- ❖ 0.8 сая төгрөгийн өглөг нь сумдын сум хөгжүүлэх сангийн дансанд андуурч гүйлгээ хийсэн, зээлдэгчийн илүү төлөлттэй холбоотой.

ОНӨҮГ-ын өр төлбөрийг тодруулбал:

ОНӨҮГ-ын 5,106.4 сая төгрөгийн өрийн 93.6 хувь буюу 4,779.5 сая төгрөгийг урт хугацаат зээлийн өр, 6.4 хувь буюу 326.9 сая төгрөгийг бусад өглөг эзэлж байна. Өр төлбөр өмнөх оноос 52.1 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ОНӨААТҮГ-ын зээлийн өглөгийг тодруулбал:

Ундрага-Алтай ОНӨААТҮГ-ын Азийн хөгжлийн банкны **418.4** сая төгрөг зээлийг 2014 онд богино хугацаат зээлийн үлдэгдэлд бүртгэсэн байсан ба 2015 онд урт хугацаат зээлийн өглөгт залруулан, МОН-2301, МОН-1847 төслийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалттай холбоотой нийт **4,796.5** сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-ын шийдвэрээр орлого авч, тайлант онд 17.0 сая төгрөгөөр хорогдож оны эцэст **4,779.5** сая төгрөгийн урт хугацаат зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн төсөвт байгууллага, ОНТҮГ-ын нийт 367.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулсан эсэхэд судалгаа хийхэд 314.9 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

5.6 ОРЛОГО, ТАТААС, САНХҮҮЖИЛТ

5.6.1 УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 9,416.9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

5.6.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ

Аймгийн 2016 оны төсвийг анх аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ны 13 дугаар тогтоолоор 53,659.6 сая төгрөгөөр баталсан ба аймгийн ИТХ-ын 2016 оны 06 дугаар сарын 07-ны 01 дүгээр тогтоолоор 55,149.5 сая төгрөг, 2016 оны 12 дугаар сарын 05-ны 09 дүгээр тогтоолоор 54,473.9 сая төгрөгөөр тус тодотгосон байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 сарын 05-ны өдрийн 09 дугаар тогтоолоор төсвийн эх үүсвэрийг дараах байдлаар баталсан: Үүнд:

- ✓ Аймгийн татварын болон татварын бус орлогыг 5,544.5 сая төгрөг
- ✓ Орон нутгийн төсвийн байгууллагын өөрийн орлогыг 28.6 сая төгрөгөөр
- ✓ ТЕЗ-ийн улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 9,416.6 сая төгрөгөөр
- ✓ Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 32,237.1 сая төгрөгөөр
- ✓ Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлогыг 66.8 сая төгрөгөөр
- ✓ Аймгийн шилжих үлдэгдлээс санхүүжигдэх дүнг 1,417.3 сая төгрөгөөр
- ✓ Тусгай сангийн шилжих үлдэгдлээс 69.4 сая төгрөг
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг 5,693.6 сая төгрөгөөр нийт 54,473.9 сая төгрөгийн орлогын эх үүсвэрээр аймгийн төсвөөс 2016 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг баталсан байна. Хавсралт-12

Орон нутгийн орлогын талаар

Аймгийн 2016 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг анх аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ны 13 дугаар тогтоолоор 5,369.9 сая төгрөгөөр баталсан ба аймгийн ИТХ-ын 2016 оны 06 дугаар сарын 07-ны 01 дүгээр тогтоолоор 5,373.1 сая төгрөгөөр, 2016 оны 12 дугаар сарын 05-ны 09 дүгээр тогтоолоор 5,573.1 сая төгрөгөөр тус тодотгосон байна.

Орон нутгийн төсвийн орлогыг 2016 онд аймаг, сумдын нийт хэмжээнд 6,421.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс 6,335.2 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 98.6 хувиар буюу 86.7 сая төгрөгөөр тасарсан байна. Хавсралт-13

**Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт
/сая төгрөгөөр/**

Орлогын нэр төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлт давсан +,тасарсан-	Хувь
ОРЛОГО	6,421.9	6,335.2	(86.70)	99%
ТАТВАРЫН ОРЛОГО	5,633.2	5,723.9	90.64	102%
Хувь хүний орлогын албан татвар	4,294.2	4,314.7	20.52	100%
Хувь хүний орлогын албан татвар	4,294.2	4,314.7	20.52	100%
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	4,410.1	4,396.2	(13.89)	100%
Үйл ажиллагааны орлого	206.1	203.0	(3.10)	98%
Хөрөнгө борлуулсны орлого	100.0	102.7	2.71	103%
Шууд бус орлого	98.0	130.0	32.02	133%
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(520.0)	(517.2)	2.77	99%
Өмчийн татвар	340.4	208.6	(131.77)	61%
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	279.8	175.2	(104.55)	63%
Бууны албан татвар	60.6	33.4	(27.22)	55%
Тусгай зориулалтын орлого	257.4	268.8	11.37	104%
МУ ын АТӨЯХАТ	257.4	268.8	11.37	104%
Бусад татвар / төлбөр хураамж /	741.2	931.8	190.52	126%
Улсын тэмдэгтийн хураамж	103.2	150.8	47.61	146%
Газрын төлбөр	207.0	210.2	3.22	102%
Ойн нөөц ашигласны төлбөр	1.3	1.4	0.15	111%
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	88.7	107.5	18.75	121%
Ус,рашааны нөөц ашигласны төлбөр	77.7	208.0	130.30	268%
АМ-аас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	-	1.9	1.90	#DIV/0!
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	110.0	120.1	10.14	109%
Бусад татвар хураамж/ нохой/	0.2	0.8	0.65	425%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	153.2	131.0	(22.19)	86%
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	788.7	611.4	(177.34)	78%
Татварын бус орлого	767.9	602.8	(165.05)	79%
Хүү торгуулийн орлого	409.1	395.3	(13.81)	97%
Төсөвт өөрийн орлого	73.0	68.7	(4.27)	94%
Бусад орлого	279.6	123.9	(155.66)	44%
Түрээсийн орлого	6.3	14.9	8.69	239%
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	20.8	8.5	(12.29)	41%
Өмч хувьчлалын орлого	20.8	8.5	(12.29)	41%

- ✓ Орон нутгийн төсвийн орлогын 90.3 % буюу 5,723.9 сая төгрөг татварын орлогоос, 9.7% буюу 611.4 сая төгрөг татварын бус орлогоос тус тус бүрджээ.
- ✓ 2016 онд нийт 11 нэр төрлийн орлогоор 273.5 сая төгрөгөөр давж биелэсэн бол, 9 нэр төрлийн орлого 356.9 сая төгрөгөөр тасарсан дүнтэй байна. Орлогын дүнгээс давсан болон тасарсан орлогыг дараах хүснэгтээр харуулья.

2016 онд батлагдсан төлөвлөгөөнөөс давсан орлого / сая төгрөг/				
Орлогын нэр төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлт давсан +,тасарсан-	Хувь
ОРЛОГО	955.9	1,229.4	273.5	129%
Шууд бус орлого	98.0	130.0	32.02	133%
МУ ын АТӨЯХАТ	257.4	268.8	11.37	104%
Улсын тэмдэгтийн хураамж	103.2	150.8	47.61	146%
Газрын төлбөр	207.0	210.2	3.22	102%
Ойн нөөц ашигласны төлбөр	1.3	1.4	0.15	111%
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	88.7	107.5	18.75	121%
Ус,рашааны нөөц ашигласны төлбөр	77.7	208.0	130.30	268%
АМ-аас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	-	1.9	1.90	100%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	110.0	120.1	10.14	109%
Бусад татвар хураамж/ нохой/	0.2	0.8	0.65	425%
Түрээсийн орлого	6.3	14.9	8.69	239%

Давсан орлогууд:

Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэл

- ❖ Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ус ашигласны төлбөр 130.3 сая төгрөгөөр давсан – “Тайшир Гуулин УЦС” ХХК-аас татварын урьд оны хяналт шалгалтын 37.6 сая төгрөг, урьд оны дутуу төлөлт 30.5 сая төгрөг төвлөрсөн. Мөн төлөвлөгөөнд тусгагдаагүй Ховд-Алтай чиглэлийн авто замд ашигласан усны төлбөрт 30.5 сая төгрөг, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй “Өү Жи Си Эйч Эйл” ХХК-аас 25.9 сая төгрөг тус тус төвлөрсөн нь уг орлого давахад нөлөөлсөн.
- ❖ Түрээсийн төлбөр 8.7 сая төгрөгөөр давсан – “Хүрийн овоо” ХХК Орон нутгийн өмчийн албаны өмчид бүртгэлтэй гражийг 2016.09.01-ээс эхлэн түрээслэж 6.8 сая төгрөгийн төлбөр төлсөн нь уг орлого давахад голлон нөлөөлсөн.

Сумдын төсвийн орлогын гүйцэтгэл

- ❖ Агнуурын нөөц ашигласны төлбөр 18.7 сая төгрөгөөр давсан –Алтай, Цогт, Жаргалан сумдад агналт хийгдсэн бөгөөд нийт орлогын 25 хувийг сумдад тодотгон зарцуулах эрх олгосон боловч Цогт, Жаргалан сум тайлант оны төсөвт тодотгол хийгээгүй учир төлөвлөгөө давсан байна.

2016 онд батлагдсан төлөвлөгөөнөөс тасарсан орлого / сая төгрөг/				
Орлогын нэр төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлт давсан +, тасарсан-	Хувь
ОРЛОГО	5,892.27	5,535.30	(356.97)	94%
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	4,410.1	4,396.2	(13.89)	100%
Үйл ажиллагааны орлого	206.1	203.0	(3.10)	98%
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	279.8	175.2	(104.55)	63%
Бууны албан татвар	60.6	33.4	(27.22)	55%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	153.2	131.0	(22.19)	86%
Хүү торгуулийн орлого	409.1	395.3	(13.81)	97%
Төсөвт өөрийн орлого	73.0	68.7	(4.27)	94%
Бусад орлого	279.6	123.9	(155.66)	44%
Өмч хувьчлалын орлого	20.8	8.5	(12.29)	41%

Тасарсан орлогууд:

Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэл

- ❖ Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 104.5 сая төгрөгөөр тасарсан - “Алтайн хүдэр” ХХК-аас 107.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч уг татвар төлөгдөөгүй өр үүссэн.
- ❖ Нэр заагдаж ангилагдаагүй бусад орлого 155.7 сая төгрөгөөр тасарсан – УИХ-ын гишүүний багцаас олгосон зээлийн эргэн төлөлтөөр 277.8 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан бөгөөд төлбөрийг барагдуулахаар ШШГА-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа боловч эргэн төлөлт хангалтгүй байна.
- ❖ Өмч хувьчлалын орлого 12.3 сая төгрөгөөр тасарсан – Бугат сумын ЗДТГ-ын зочид буудлын барилга, Бугат сумын Цагдаагийн кабоны барилга, Хөхморьт сумын ЭМТ-ийн хуучин барилгыг хувьчлахаар төлөвлөсөн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.2.3-т заасны дагуу Төрийн өмчийн хороотой зөвшилцөхөөр санал хүргүүлсэн боловч Төрийн өмчийн хороо болон Орон нутгийн өмчийн албаны бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөс шалтгаалан хувьчлах хөрөнгийн жагсаалтад орж батлагдаагүй учраас төлөвлөсөн орлого тасарсан.
- ❖ Төсөвт байгууллагын өөрийн орлого 4.3 сая төгрөгөөр тасарсан – Худалдан авах ажиллагаа нь өөрийн орлогоор 10.0 сая төгрөг төвлөрүүлэхээр тооцсон боловч 4.1 сая төгрөг төвлөрүүлсэн нь уг орлогын төлөвлөгөө тасрахад голлон нөлөөлсөн.

Сумдын төсвийн орлогын гүйцэтгэл

- ❖ Галт зэвсгийн албан татвар 27.2 сая төгрөгөөр тасарсан –Дэлгэр, Хөхморьт, Есөнбулаг сумаас бусад сумын төлөвлөгөө тасарсан бөгөөд Цагдаагийн газрын бүртгэлд шилжилт хөдөлгөөн бүрэн хийгддэггүй, эзэмшигч нь давхардаж бүртгэгдсэн зэрэг зөрчилтэй байгаагаас шалтгаалсан байна.
- ❖ Хог хаягдлын үйлчилгээний хураамж 22.2 сая төгрөгөөр тасарсан – Бигэр, Тайшир, Цээл, Хөхморьт, Шарга сумаас бусад сумын төлөвлөгөө тасарсан бөгөөд сумын үйл ажиллагаанаас шалтгаалсан байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн харьцуулсан судалгааг дараах графикаар харуулья.



Татварын болон татварын бус орлогын нийт төлөвлөгөөг Есөнбулаг сум 39.4 сая төгрөгөөр, Баянтоорой тосгон 2.8 сая төгрөгөөр, аймгийн төв 129.8 сая төгрөгөөр, нийт 172.0 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Өмнөх жилийн санхүүгийн аудитаас орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх тал дээр анхаарч ажиллах талаар албан шаардлага хүргүүлж байсан боловч энэ жилийн төсвийн орлогын нэр төрлийн гүйцэтгэлээс харахад шийдвэрийн биелэлт хангалтгүй байна. Орон нутгийн орлогын тасарсан шалтгаанаас үзэхэд орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөснөөс гадна татварын орлого оруулах эрх бүхий албан тушаалтны хариуцлагагүй ажилласантай холбоотой байна гэж үзлээ.

5.7 ЗАРЛАГЫН ТАЛААР

5.7.1 САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

Аймгийн 2016 оны тодотгосон төсөв батлах тухай Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 сарын 05-ны өдрийн 09 дугаар тогтоолоор аймгийн төсвийн нийт зарлагыг 54,473.9 сая төгрөгийн төсвийн зарлага гаргахаар баталсан бөгөөд сумдын орон нутгийн болон, шилжих үлдэгдлээс санхүүжүүлэх төлөвлөгөөг нэмж нийт 57,593.0 сая төгрөгийн зардал гаргахаар баталж гүйцэтгэлээр 52,738.8 сая төгрөгийн зардал гаргасан байна.Хавсралт-14, 15

Тайлант онд Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын дагуу төсөвт байгууллагууд аймгийн төрийн сангаас зөвшөөрөл авч гүйлгэн зарцуулалт хийгдээгүй байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2016 оны “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 07 дугаар тушаалын дагуу эдийн засгийн ангилалаар, бүлгийн дүнгээр авч үзвэл дараахь байдалтай байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн 2016 оны төсвийн гүйцэтгэл

№	ЗАРДЛЫН БҮЛЭГ	2016				Нийт зардалд эзлэх хувь
		Өмнөх он	Төсөв	Тайлант он	хэмнэлт+, хэтрэлт-	
2101	Цалин хөлс нэмэгдэл урамшил	21,117.6	26,259.7	25,140.3	1,119.4	47.6 %
2102	Ажил олгогчоос төлөх НДШ	2,700.7	2,925.4	2,780.4	144.9	5.3 %
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,247.0	4,777.0	4,620.8	156.1	8.8 %
2104	Хангамж бараа материалын зардал	1,071.9	1,186.1	1,155.0	31.0	2.2 %
2105	Нормативт зардал	2,103.0	2,104.4	2,001.6	102.2	2.6 %
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	684.2	623.6	600.3	23.2	0.0 1%
2107	Томилолт, зочны зардал	274.6	305.3	281.9	23.3	0.5 %
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	264.3	1,319.0	1,145.0	174.0	2.2 %
2109	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	1,442.3	1,380.1	1,215.5	164.0	2.3 %
2131	Татаас, замын сан	188.3	14.0	14.0	0	0.02 %
2132	Урсгал шилжүүлэг	6,147.4	6,905.6	6,518.4	387.2	12.3 %
220	Хөрөнгийн зардал	8,925.6	7,980.2	6,445.9	1,534.2	12.2 %
23	Эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	1,812.1	819.1	993.0	1.5%
	Дүн	57,954.5	57,593.0	52,738.8	4,854.1	100.0

2016 оны төсвийн гүйцэтгэл 52,738.8 сая төгрөг байгаа нь төлөвлөсөнтэй харьцуулахад 91 хувийн биелэлттэй байна. Нийт зардлын 47.6 хувийг цалин хөлсний зардалд, 5.3 хувийг НДШ-ийн зардалд, 8.8 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 2.2 хувийг хангамж бараа материалын зардалд, 2.6 хувийг нормативт зардалд, 0.01 хувийг эд хогшил урсгал засварын зардалд, 0.5 хувийг томилолт зочны зардалд, 2.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт, 2.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 11.9 хувийг бусад урсгал шилжүүлэгт, 12.2 хувийг хөрөнгийн зардалд, 1.5 хувийг эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардалд зарцуулсан байна.

Төсвийн санхүүжилт, Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн талаар

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байгууллагуудын хувьд 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу аймаг, сумдын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төрийн санд сар бүр хүсэлт баталгааны маягтыг гарган өгч, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагуудын төсвийн төлөвлөгөө гүйцэтгэлийг нэг бүрчлэн тооцоход бүлгийн дүнгээр 25.8 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3 /Төрийн сан төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх үүрэгтэй/ гэж заасны дагуу төрийн сангийн чиг үүрэг хэрэгжихгүй байгааг харуулж байна. Хавсралт-16

“Сангийн сайдын 2014 оны 05 дугаар тушаалын 06 дугаар хавсралтын дагуу төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг баримтлан ажиллаагүйгээс төсөвт байгууллагуудын

төсвийн гүйцэтгэл төсвийн хэлбэлзлээс 28.9 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Цаашид Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам түүнтэй холбогдон гарсан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна. Хавсралт-17

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зардлын данстай холбоотой нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам, заавар мөрдөөгүй, дансны бичилт буруу хийсэн, төсвийг зориулалт бусаар, үрэлгэн, үр ашиггүй зарцуулсан зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

Цалин, хангамж, томилолт, эд хогшил, нийгмийн хамгаалал, зочны болон нормативт зардлуудыг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- ✓ Цалингийн урьдчилгааг суутгаагүй, цалин хөлс, үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон, анхан шатны нотлох баримтгүйгээр албан томилолт, унаа, байр хоолны зардлыг олгосон, тэтгэмжийг үндэслэлгүйгээр олгосон зэрэг **147.5** сая төгрөгийн зөрчил илэрснийг байгууллагуудаар нь авч үзвэл Алтай, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тонхил, Төгрөг, Хөхморьт, Есөнбулаг сумдын нэгж байгууллагуудын зөрчил эзэлж байна.
- ✓ УИХ-ын 2016 оны 47-р тогтоолыг зөрчиж албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлсэн 3.5 сая төгрөгийн, тавилга эд хогшил бэлтгэсэн 9.8 сая төгрөгийн зөрчил илэрснийг Дэлгэр, Тонхил, Цогт сум, Есөнбулаг сумын болон Баянтоорой тосгоны төсөвт байгууллагуудын зөрчил эзэлж байна.
- ✓ Ажилчдын цалинг Нийгмийн даатгалд зөрүүтэй тайлагнасан, цалингаас НДШ, ХХОАТ дутуу суутгасан зэрэг нийт 35.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
- ✓ Батлагдсан орон тооноос илүү ажиллуулсан 14.5 сая төгрөгийн зөрчил аймгийн ЗДТГ-т илэрсэн.
- ✓ Төрийн сангийн тамга тэмдэг дарж баталгаажуулаагүй гүйлгээ хийсэн 154.2 сая төгрөгийн зөрчил илэрснийг Дэлгэр сумын Гуулин тосгоны төсөвт байгууллагууд эзэлж байна.
- ✓ Анхан шатны баримтгүйгээр, баримтын бүрдэл дутуугаар зардал гаргасан 218.8 сая төгрөгийн зөрчил Алтай, Дарив, Дэлгэр, Халиун, Эрдэнэ, Есөнбулаг сум, Гуулин, Баянтоорой тосгоны болон аймгийн төвийн төсөвт байгууллагуудаас илэрсэн.
- ✓ Жолоочийн шатахууны тооцоог бодоогүй, шатахууны зардлыг юунд зарцуулсан нь тодорхойгүй анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, замын хуудасгүйгээр зарцуулсан 80.9 сая төгрөгийн зөрчлийг Дарив, Төгрөг, Халиун, Эрдэнэ, Есөнбулаг сумын болон аймгийн төсөвт байгууллагуудад илэрсэн.

Тариалан эрхлэлтийг дэмжих сантай холбогдуулж дараах зөрчил илэрсэн.

- ✓ Иргэдэд гэрээгээр нийлүүлсэн тракторын үнийг буцаан төлөлтийг тооцоход гэрээт хугацаанд 57.6 сая төгрөгийн үндсэн үнэ, хүүг төлүүлээгүй, гэрээний дагуу тооцсон алдангийг төлүүлээгүй.
- ✓ Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хүлэмжний үнэ, үрийн төмсний үнэ, хүнсний ногооны үрийн үнэ, жимсний суулгацны үнийг төлүүлээгүй, Хүнс хөдөө аж ахуйн яам болон ААН байгууллагуудад өгөх өглөгийг барагдуулаагүй, аудитын явцад төлөгдсөн мөнгөн орлого нь хэнээс төлөгдсөн нь тодорхойгүй 130.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Сум хөгжүүлэх сантай холбогдуулж дараах зөрчил илэрсэн.

- ✓ СХС-аас олгох зээлийн гэрээний гэрээт хугацаанд төлүүлээгүй үндсэн зээл, хүү, гэрээний дагуу үндсэн зээлээ төлөөгүй иргэдэд торгууль ногдуулсан 961.3 сая төгрөгийн, зээл олгосон иргэдтэй хүчин төгөлдөр гэрээ байгуулаагүй 55.6 сая

төгрөгийн, Шүүхийн шийдвэрээр төлөхөөр тогтоогдсон зээлдэгчдийн төлөгдөөгүй үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд гэрээ хийж барагдуулах арга хэмжээ аваагүй 95.9 сая төгрөгийн зөрчил бүх сумдад илэрсэн.

- ✓ Удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон 150.3 сая төгрөгийн зөрчил Дэлгэр, Жаргалан, Халиун, Чандмань, Шарга, Эрдэнэ, Есөнбулаг сумын болон аймгийн төвийн төсөвт байгууллагуудад илэрсэн гэх мэт зөрчлүүд илэрсэн.

Бусад санхүүгийн тайлагналттай холбоотой зөрчлийг аудит хийх бүртээ нэгж байгууллагад нягтлан бодогчийн хүлээн зөвшөөрсний дагуу залруулга хийсэн.

5.7.2 НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР:

Тайлант онд орон нутгийн салбарын байгууллагууд 1,147.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн судалгаа

Салбарын ангилал	Авсан нэмэлт санхүүжилт /сая/төг/
Орон нутгийн төсвийн байгууллагууд	521.7
Боловсрол Соёл Шинжлэх ухааны сайд	119.3
Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайд	126.6
Эрүүл мэндийн сайд	213.6
Барилга хот байгуулалтын сайд	166.7
Дүн	1,147.9

5.7.3 ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд нь **32,237.0** сая төгрөгийн санхүүжилт, **66.0** сая төгрөгийн өөрийн орлогын төлөвлөгөөтэй ба гүйцэтгэлээр бүрэн санхүүжигдэж үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогоор **108.4** сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэлээр **30,821.8** сая төгрөгийг зарцуулсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/Сая.төгрөг/

д/ д	Салбар	Тусгай шилжүүлэг	зориулалтын	Өөрийн орлого		Нэгдсэн тайлангаарх төлөвлөгөө	Нэгдсэн тайлангаарх гүйцэтгэл	Хэтрэлт+ хэмнэлт-
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	
1	БСШУ-ны сайд	27,333.2	25,897.9	66.6	65.5	27,399.8	25,963.4	1,436.4
2	БХБ-ын сайд	183.9	177.1	0	42.8	183.9	219.9	-36
3	ХАХНХ- ийн сайд	336.9	336.9	0	0	336.9	336.9	0
4	ЭМ-ийн сайд	4,382.9	4,301.5		0.18	4,382.9	4,301.68	81.22
	Дүн	32,237.0	30,713.4	66.6	108.48	32,303.5	30,821.88	1,481.62

Төсвийн гүйцэтгэл 95.4 хувьтай буюу **30,821.8** сая төгрөг байгаа нь Барилга хот байгуулалтын сайдын багцаас 121.6 сая төгрөг, БСШУ-ын сайдын багцаас 1,394.8 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын багцаас 82.0 сая төгрөг нийт 1,598.4 сая төгрөгийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

5.7.4 ОНӨААТҮГ-ЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЛААР:

ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдэг 7 ОНӨААТҮГ-уудын ашиг алдагдлын судалгааг хийж үзэхэд “Орон сууцны алба” ОНӨААТҮГ, “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ууд нь 2016 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй, Ундрага-Алтай ОНӨААТҮГ-аас бусад ОНӨААТҮГ-ууд нь байгууллагын бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөөгүй, гүйцэтгэлийг дүгнэж үр дүнг тодорхойлоогүй, нэгтгэсэн тайлангаар “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ-аас бусад ААНБ-ууд 590.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд тайлант хугацааны элэгдлийн зардлыг хасаж тооцвол 262.5 сая төгрөгийн цэвэр алдагдалтай ажилласан байна. Энэ нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөгүй, орлого зарлагын тооцоо судалгаа хийдэггүйтэй холбоотой байна. Орон нутгийн төсвөөс 2013-2016 онуудад “Гэгээн нуур эрүүл ус” ОНӨААТҮГ-т 1,763.6 сая төгрөгийн, “Орон сууцны алба” ОНӨААТҮГ-т 20.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Мөн “Орон сууцны алба” ОНӨААТҮГ-т Солонго хорооллын хяналтын зардалд зориулж 56.6 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгожээ. Хавсралт-18

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д /Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг /цаашид “захирал” гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана. 1./энэ хуульд заасан эрх үүрэг, 2/ эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүрэх төвшин, 3/ техник технологийг шинэчлэх даалгавар, 5/менежментийн бодлого, 6/ захирлаас болон үүргээ биелүүлэх талаар төрөөс хүлээх үүрэг, 10/энэ хуульд заасан эд хөрөнгийн хариуцлага, 11/ гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх журам хугацааг тусгана/ 19.2-т Захирал гэрээгээр тохиролцсон үүргээ биелүүлээгүй нь хүндэтгэн үзэх бодит шалтгаангүй бол түүнийг ажлаас халах үндэслэл болно/, 20.1.3 дахь заалт /Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангуулах/ гэж заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгддэг ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, ашигт ажиллагааны түвшин, үр дүнг дээшлүүлэх ажил зохион байгуулах нь зүйтэй байна.

5.8 ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮНГИЙН ТАЛААР

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хуримтлагдсан үр дүн 2015 оны эцэст **18,614.2** сая төгрөг байснаас 68.7 хувиар өсч **27,071.1** сая төгрөгөөр тайлагнагдсан, тайлант хугацаанд 5,694.9 сая төгрөгийн ашигтай байна.

Хуримтлагдсан үр дүн / сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Хуримтлагдсан үр дүн	18,614.2	27,071.1	-8,456.9
Өмнөх үеийн үр дүн		21,376.1	
Тайлант үеийн үр дүн		5,694.9	

5.9 ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ТАЛААР

Орон нутгийн нэгтгэсэн тайлангийн Засгийн газрын капитал / орон нутгийн сан/ 2015 оны эцэст 48,999.5 сая төгрөг байсан бол тайлант онд 48,969.0 сая төгрөг болж 30.5 сая төгрөгөөр буурсан байна.

**ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИД БОЛОН ТҮҮНИЙ
ХАРЪЯА БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮН,
ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН ТАЛААР:**

Үндсэний Аудитын газрын харьяа Говь-Алтай аймаг дахь Төрийн Аудитын газар нь Төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.2, 8.9.3 дахь заалтын дагуу орон нутгийн төсвийн шууд захирагчдийн 150, сумын ТЕЗ-20, сумдын төсөл сангийн-58, ОНӨҮГ-ын-7 нийт 236 санхүүгийн тайлан аудитад хамрагдахаас төсвийн шууд захирагчдын 89, сумын ТТЗ-ийн 20, төсөл сангийн -20, ОНӨҮГ-ын-4 нийт 133 санхүүгийн тайлан аудит хийж санал дүгнэлт өгч, 20 санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 78 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа.


Орон нутгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын Аудитын санал дүгнэлтийг авч үзвэл 75 санхүүгийн буюу 56.4 хувь нь “Зөрчилгүй санал дүгнэлт”, 48 санхүүгийн тайлан буюу 36.0 хувь нь “Хязгаарлалттай санал дүгнэлт” 10 санхүүгийн тайлан буюу 7.6 хувь нь “Сөрөг санал дүгнэлт” өгсөн байна. Хавсралт-19

Орон нутгийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах байдлаар хураангуйлан тэмдэглэв.

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгж байгууллагуудын аудитаар нийт 20,662.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 4,977.0 сая төгрөгийн зөрчлийг залруулсан ба 1,174.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,971.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2,539.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Нийт зөрчлийн **75.9** хувь буюу **15,683.3** сая төгрөгийн алдаа зөрчил аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нөлөөлөх материаллаг алдаа зөрчил байна гэж үзлээ.


Аудитын явцад илэрсэн нийт алдаа зөрчлийг холбогдох салбараар харуулбал
/ сая төгрөг/



Нийт алдаа зөрчлийн 35.8 хувь буюу 7,401.9 сая төгрөгийн зөрчлийг орон нутгийн төсвийн, 45.6 хувь буюу 9,612.6 сая төгрөгийн зөрчлийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд, 13.8 хувь буюу 2,857.3 сая төгрөгийн зөрчлийг төсөл сан, 3.8 сая төгрөгийн зөрчлийн ОНӨААТҮГ-ын зөрчлүүд тус тус эзэлж байна. Хавсралт-20, 21

Нийт алдаа зөрчлийн 33.1% буюу **6,839.6** сая төгрөг нь бүртгэл тайлагналтай холбоотой 66.9% буюу **13,822.7** сая төгрөг нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг графикаар харуулбал
/сая төгрөг/



Дээрх графикаас үзэхэд нийт алдаа зөрчлийн ихэнх буюу 56.8 хувь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой байна.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг өмнөх оныхтой харьцуулбал:

2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,671.3 сая төгрөгийн алдаа зөрчил, 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 21,806.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч байсан бол 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 20,662.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн нь 2015 оныхоос илэрсэн зөрчил буураагүй байгааг харуулж байгаа төдийгүй төсөв захирагчид санхүүгийн сахилга баттай ажиллах шаардлагатай болж байгааг илтгэж байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаар илэрсэн зөрчлүүд болон тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний нийт 399.8 сая төгрөгийн дараах алдаа, зөрчил илэрсэн байна.Үүнд:

Аймгийн Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд:

1. "Орон сууцны алба" ОНӨААТҮГ нь Аудитын газарт 2016 оны санхүүгийн тайланг ирүүлээгүйн улмаас аудит хийгдээгүй байна.

Шийдвэрлэлт: "Төсвийн тухай хуулинд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа гаргаж ирүүлээгүй "Орон сууцны албаны дарга С.Эрдэнэ-Очирт хуулийн дагуу хариуцлага тооцох" албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

2. 2014 онд ҮАГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтын үр дүн"-д хийсэн нийцлийн аудит болон 2014, 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,375.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон боловч 508.6 сая төгрөгийн зөрчлийг барагдуулан, 866.4 сая төгрөгийг барагдуулаагүй байна. Мөн 2016 оны санхүү тайлангийн аудитаар 2015 оны СТА-аас хойших хугацаанд гэрээний дагуу үндсэн зээл, хүүгээ төлөөгүйд нэмж 961.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон, нийт 1,828.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн үндсэн зээл, зээлийн хүү, алдангийг төлөөгүй байна.

Шийдвэрлэлт: "Сум хөгжүүлэх сангийн их хэмжээний хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ авч, алдангийг хөшүүрэг болохуйц түвшинд тогтоож, бүх талын хариуцлагыг сайжруулан ажиллах" албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

3. Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах нэгж байгууллагуудын тухайд удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр 118.3 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгож, НДШ-д 4.3 сая төгрөг, ХХОАТ-т 0.7 сая төгрөг, тэмдэгтийн хураамжид 0.3 сая төгрөг төсвөөс төлж 123.5 сая төгрөгийг буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон.

Шийдвэрлэлт: "Байгууллагад хохирол учруулсан гэм буруутай этгээдээр учирсан хохирлыг төлүүлэх арга хэмжээ авах" албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

4. ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг ОНӨААТҮГ-уудын судалгаа хийж үзэхэд "Орон сууцны алба" ОНӨААТҮГ, "Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ-ууд нь 2016 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй, ОНӨААТҮГ-ууд байгууллагын бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөөгүй, гүйцэтгэлийг дүгнэж үр дүнг тодорхойлоогүй, нэгтгэсэн тайлангаар Эрдэнэ эрчим хүч ОНӨААТҮГ-аас бусад ААНБ-ууд 590.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд тайлант хугацааны элэгдлийн зардлыг хасаж тооцвол 262.6 сая төгрөгийн цэвэр алдагдалтай ажиллажээ. Энэ нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөгүй ажилласантай холбоотой байна.

Шийдвэрлэлт: "Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгддэг ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, ашигт ажиллагааны түвшин, үр дүнг дээшлүүлэх ажил зохион байгуулах" албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

5. "Бигэр сумын Сум хөгжүүлэх сангийн авлагыг 1.7 сая төгрөгөөр дутуу тайлагнаж, Бигэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэсэн.
6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг нэгж байгууллагуудын авлага өглөгийн дэлгэрэнгүй судалгаа хийхэд 165.5 сая төгрөгийн авлагыг, 297.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.
7. Нэгж байгууллагуудын санхүүгийн тайланд тусгагдсан нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өглөгийг Нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн судалгаатай

тулган үзэхэд 16.4 сая төгрөгөөр, татварын авлага өглөгийг Татварын хэлтсээс ирүүлсэн судалгаатай тулган үзэхэд 32.3 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.

Шийдвэрлэлт: “Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулан барагдуулах арга хэмжээ авч, үнэн зөв тайлагнах” албан шаардлагыг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогчид хүргүүлээ.

8. "Байгаль орчны газрын 375.9 сая төгрөгийн, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 443.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгдэж байгаа боловч Төрийн өмчид бүртгэлтэй байна.

Шийдвэрлэлт: “Байгаль орчны газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлж авах ажил зохион байгуулах” албан шаардлагыг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогчид хүргүүлээ.

9. "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилалыг баримтлан ажиллаагүйгээс нэгж байгууллагын төсвийн гүйцэтгэл төсвийн хэлбэлзлээс 28.9 сая төгрөгөөр зөрүүтэй бөгөөд төсвийг 25.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

10. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 86.7 сая төгрөгөөр тасалсан.

Шийдвэрлэлт: “Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам түүнтэй холбогдон гарсан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах” албан шаардлагыг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогчид хүргүүлээ.

11. "Орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 20,662.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 4,977.0 сая төгрөгийн алдааг залруулсан ба 1,174.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,971.1 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлж, 24 албан тушаалтанд хариуцлага тооцох санал явуулж, 2,539.5 сая төгрөгийн зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Шийдвэрлэлт: “Нэгж байгууллагад өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, холбогдох ажилтнуудын эрх үүргээ хэрэгжүүлэх явцад хяналт тавьж ажиллах” албан шаардлагыг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогчид хүргүүлээ.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд алдаа залруулаагүй болно.

ДОЛОО. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх шийдвэрийн хэрэгжилт:

ДД	НЭҮ, Байгууллага, сангийн нэр	сая төгрөг					
		Өгөгдсөн		Хэрэгжүүлсэн		Хэрэгжүүлээгүй	
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Төлбөрийн акт	Албан шаардлага	Төлбөрийн акт	Албан шаардлага
Дүн		1,631.3	7,641.0	650.8	5,493.2	969.7	2,147.8

ТЕЗ-ийн нэгж байгууллагуудад 2014, 2015, 2016 онд СТА, НА, ГА-аар нийт 1,631.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 650.8 сая төгрөгийн актыг төлж, 969.7 сая төгрөгийн актыг барагдуулаагүй байна. Харин 7,641.0 сая төгрөгийн албан шаардлагыг төсөвт байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд 82.6 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж, 2,147.8 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

- ✓ Хэрэгжүүлээгүй албан шаардлагын хувьд 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-т 1,953.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн боловч тус байгууллагыг Авлигатай тэмцэх газар шалгасан, улмаар 2016 оны санхүүгийн тайлангийн аудит хамрагдаагүй болно.
- ✓ Хэрэгжүүлээгүй төлбөрийн актын хувьд 866.4 сая төгрөг нь Сум хөгжүүлэх санд хийгсэн аудитын шийдвэртэй холбоотой учраас сангийн их хэмжээний хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ авч, алдангийг хөшүүрэг болохуйц түвшинд тогтоож, бүх талын хариуцлагыг сайжруулан ажиллах шаардлагатай байна. Хавсралт-22

НАЙМ. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дээр дурдагдсан 20,662.3 сая төгрөгийн алдаа зөрчил нь нэгж байгууллагуудын төсвийн шууд захирагчдын болон төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар тогтоогдсон алдаа зөрчил бөгөөд уг алдаа зөрчлүүдийг тухай бүр хязгаарлалттай санал дүгнэлт өгөх, хугацаатай албан шаардлага хүргүүлэх, төлбөрийн акт тогтоох, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулж, зөвлөмж хүргүүлэн аудитын явцад холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Харин ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд өгөгдсөн 399.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тооцсон материаллаг байдлын түвшинд байгаа тул Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн тул “**Зөрчилгүй**” санал дүгнэлт өгөхийг санал болгож байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 10 хуудас, төлбөр зөрчлийн жагсаалт 1 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Ж. БҮЖИНХАНД

ШИНЖЭЭЧ

Г.ЭНХДЭЛГЭР

АУДИТОР

Г.ЦЭЦЭГМАА

2016.04.19